



ДЭЛХИЙН ЭНХИЙН
ИХ НААДАМ



СОЛОНГОСЫН НЭГДЛИЙГ
ДЭМЖИХ МОНГЛЫН ФОРУМ



ЦЭНХЭР СҮЛД



ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ



МОНГОЛ УЛСЫН
ИХ СУРГУУЛЬ



АЮУЛГҮЙ БАЙДАЛ
СТРАТЕГИЙН ИНСТИТУТ

"ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО"

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4-р хороо, Сүхбаатарын гудамж-8/5,
Пийс Бюлдинг, 507 тоот
Утас: 99034632, 11-331758
И-мэйл: sarantuya@globalpeace.org

огноо _____ № _____
танай _____ - № _____ -т



Y4RP-2021

ТӨСӨЛТ-ИЛТГЭЛИЙН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Y4RP ГЭЖ ЮУ ВЭ?

YOUTH FOR REGIONAL PEACE & PROSPERITY-2021 бол их, дээд сургуулиудын оюутан залуус болон сургуулиа төгсөөд **НИЙГЭМД ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ ТҮГЭЭХ** буюу нийгэмд ач холбогдолтой хэрэгжих боломжтой бодитой шийдлийг санаачлах, эерэг өөрчлөлтийг өөрөөсөө эхлүүлээд явж буй, бүтээлч хэн бүхэнд нээлттэй уралдаан бөгөөд “Зүүн Хойд Азийн бүс нутгийн энх тайван, хөгжил цэцэглэлтэнд залуучуудын оруулах хувь нэмэр” сэдвийн хүрээнд төсөл бичиж, мэргэжлийн өндөр түвшний **МЕНТОР**-уудаас зөвөлгөө, чиглүүлэг авч хамтран хөгжүүлээд зогсохгүй **ТӨСЛИЙН ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨРТ** хамрагдах боломж бүхий уралдаан юм.

2021 ОНД 7 ДАХЬ ЖИЛДЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГЭЖ БАЙНА.

“Y4RP” ҮЙЛ ЯВЦЫН ТУХАЙ:

- **I шат: ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН САНААГ ТУСГАСАН 2 МИНУТЫН БИЧЛЭГ**
Уг бичлэг нь хэрэгжүүлэхээр зорьж буй **төслийн гол утга санааг** тусгасан бичлэг байх/бичлэгийн стандартад нийцсэн байх/ бөгөөд фэйсбүүк хуудсанд байршуулж лайк, шэйр, коммент болон шүүгчдийн оноог харгалзан үзэж дараагийн шатанд шалгаруулна.
- **II шат: ӨӨРСДИЙН БОЛОВСРУУЛСАН ТӨСЛӨӨ ИЛГЭЭХ**
2-р шатанд шалгарсан багууд төслөө эх болон хураангуйн хамт илгээх
Мөн төслийн санаагаа шүүгчдэд тайлбарлах зорилго бүхий видеог илгээх, шүүгчидтэй онлайнаар холбогдон төсөлтэй холбоотой шүүгчдийн асуултанд хариулж тэнцсэн багууд дараагийн шатанд шалгарна.

- **III шат: ТӨСЛИЙН ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨРИЙН ШАТ**
3-р шатанд шалгарсан багууд **ТӨСЛИЙН ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨРТ** хамрагдан өөрсдийн төслөө илүү сайжруулах, улмаар шилдэгийн шилдэг **1 БАГИЙН 1 ТӨСӨЛ** шалгарна.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Баг 3 хүнээс бүрдсэн байх
- Баг бүрт заавал 1 зөвлөх багш, эрдэмтэн эсвэл мэргэжлийн судлаач байх /багийн гишүүдээс гадна/
- Дэвшүүлж буй асуудал нь бүс нутгийн нийтлэг асуудал, нийтлэг сонирхлыг агуулсан байх
- Хэрэгжүүлэх гэж буй төслийн үр дүн хэмжигдэхүйц байх
- Хэрэгжүүлэх гэж буй төслийн чиглэл дээр ажилсан туршлагатай эсвэл санаагаа туршаад эхлүүлсэн байх
- Хэрэгжүүлэх гэж буй төсөл богино хугацаанд хэрэгжин, үр дүнгээ өгч эхлэх боломжтой байх

ХАМРАХ ХҮРЭЭ:

Их, дээд сургуулиудын оюутан залуус болон сургуулиа төгсөөд **НИЙГЭМД ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ ТҮГЭЭХ** буюу нийгэмд ач холбогдолтой хэрэгжих боломжтой бодитой шийдлийг санаачлах, аль хэдийнээ нийгмийн асуудалд өөрийн хувь нэмрээ оруулаад явж буй хэн бүхэнд нээлттэй 17-25 насны залуучууд

ШАГНАЛЫН САН:



2-р шатанд тэнцсэн бүх багуудыг **ТӨСЛИЙН ХУРДАСГУУР ХӨТӨЛБӨРТ** хамрагдуулах

Багийн шагнал:

- **I БАЙР – ӨРГӨМЖЛӨЛ /1.000.000 ₮ + БНСУ, СӨҮЛ хотод болох олон улсын форумд оролцох урилга/**
- **II БАЙР – ӨРГӨМЖЛӨЛ /500.000 ₮/**
- **III БАЙР – ӨРГӨМЖЛӨЛ /250.000 ₮/**


Удирдагч багшийн шагнал:


- **I БАЙР – БАТЛАМЖ /300.000 ₮/**
- **II БАЙР – БАТЛАМЖ /200.000 ₮/**
- **III БАЙР – БАТЛАМЖ /100.000 ₮/**



 <https://www.facebook.com/eastnorthasiapeace/>

 neamongolia@gmail.com

 Улаанбаатар хот, ЧД, 4-р хороо, Сүхбаатарын гудамж-8/5, Пийс Бюлдинг, 507

 88194632